



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 2 сарын 19 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, мөн зүйлийн 8.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалт, "Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед буюу 2020 оны 2 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд байгууллагын байрны аюулгүй байдалд хяналт тавих зорилгоор дараах албан хаагчдыг хариуцлагатай жижүүрээр томилсугай.

- 2020 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Ө.Мөнхтуяа
- 2020 оны 02 дугаар сарын 23-ны өдөр М.Сумъяа
- 2020 оны 02 дугаар сарын 24-ны өдөр С.Ганзориг
- 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр С.Урангэрэл
- 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Д.Энхчимэг

2. Хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэх хугацаанд 2-оос доошгүй удаа эргүүл шалгалт хийж тухай бүрт нь тэмдэглэл хийх, тус хугацаанд ажлын байрны цахилгаан, гал, усны болон бусад гэмтэл, зөрчил бусад хүчин зүйл тохиолдсон тохиолдолд нэн даруй тус газрын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга /С.Ганзориг/-т болон бусад холбогдох байгууллагад мэдэгдэж, зохих арга хэмжээ авч ажиллахыг хариуцлагатай жижүүрт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга /С.Ганзориг/-д даалгасугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР